

## С ХЭСЭГ: НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ БҮЛЭГ С9- ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

### Агуулга

|          |                                    |          |
|----------|------------------------------------|----------|
| <b>9</b> | <b>ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ</b>            | <b>2</b> |
| 9.1      | ТАНИЛЦУУЛГА                        | 2        |
| 9.2      | ХАМРАХ ХҮРЭЭ                       | 2        |
| 9.2.1    | Тодорхойлолт                       | 2        |
| 9.2.2    | Орон зайн хамрах хүрээ             | 3        |
| 9.2.3    | Цаг хугацааны хамрах хүрээ         | 3        |
| 9.3      | НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ                 | 3        |
| 9.3.1    | Нөлөөллийн тойм                    | 3        |
| 9.3.2    | Шууд хөдөлмөр эрхлэлтийн боломжууд | 3        |
| 9.3.3    | Шууд бус хөдөлмөр эрхлэлт          | 11       |
| 9.4      | ҮЛДЭГДЭЛ НӨЛӨӨЛЛИЙН ТОЙМ           | 17       |

### Хүснэгт

|              |   |   |
|--------------|---|---|
| Хүснэгт 9.1: | Төслийн ажиллах хүчний тооцоо, 2009 - 2018*   | 4 |
| Хүснэгт 9.2: | Хөдөлмөрийн ур чадварын судалгаа 2011 оны 8-р сарын байдлаар (2011 оны 8-р сараас хойш) | 5 |
| Хүснэгт 9.3: | Ажиллагсдын тоо (оршин суугаа газар, хүмүүс), 2011 оны 11-р сарын байдлаар              | 4 |
| Хүснэгт 9.4: | Хөдөлмөр эрхлэлтийн нөлөөллийн хураангуй  | 5 |

## 9 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

### 9.1 ТАНИЛЦУУЛГА

БОННБҮ-ний энэхүү бүлэгт Оюу Толгой төслийн нөлөөллийн бүсийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн шууд болон шууд бус нөлөөлөлд үзүүлэх нөлөөллийн тухай өгүүлнэ. Мөн энэ бүлэгт Оюу Толгой болон төслийн гэрээт гүйцэтгэгчдийн зүгээс бий болгож буй хөдөлмөр эрхлэлттэй холбоотой шууд нөлөөлөл, төсөлд бараа, үйлчилгээ нийлүүлснээс үүсэх хоёрдогч хөдөлмөр эрхлэлттэй холбоотой шууд бус нөлөөллийг авч үзнэ.

Нөлөөллийн бүсэд (тухайлбал тус газар нутагт томоохон нэмэлт ажиллах хүч үүсч байгаагаас гарах нөлөөлөл) хүн амын шилжилт хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой нөлөөллийг: *C8: Хүн ам ба хүн амын шилжилт хөдөлгөөн* бүлэгт; уламжлалт амьжиргааны хэв маягт гарч буй өөрчлөлттэй холбоотой нөлөөллийг *C11: Соёлын өв* бүлгээс харна уу.

Төслийн барилгын ажлын үе шат ихээхэн ахисан түвшинд ирээд байгаа тул ажлын байр (Оюу Толгой төслөөс олгож буй шууд ажлын байр болон бараа, үйлчилгээ хангах байдлаар бий болох шууд бус ажлын байр) болон ажилчид, төслийн гэрээт гүйцэтгэгчид, тэр дундаа Ханбогд сумаас авсан ажилчдын тоо ихээр нэмэгдэж байна. Энэ үйл явцыг зохицуулж, төслөөс орон нутгийн хөдөлмөр эрхлэлтэд оруулах хувь нэмрийг дээд зэргээр нэмэгдүүлэхийн тулд Оюу Толгой компаниас ажилтан хөлслөх, ажилд авах талаар нарийн бодлого, журмыг боловсруулж, *Ажиллах хүчний тооллогоор* дамжуулан ажиллах хүчний нөөц боломжийн талаар өргөн хүрээтэй судалгаа хийсэн. Орон нутгаас ажиллах хүч авах асуудлын талаар Хөрөнгө Оруулалтын Гэрээ (ХӨОГ)-нд төслийн бүхий л шатанд Монгол ажилчдын тоо нийт ажилчдын ихэнхи хувийг эзэлж байхаар заасан байдаг бөгөөд бусад хууль эрх зүйн баримт бичгүүдээр зохицуулдаг.

Үйлдвэрлэлийн үе шат болон уурхайг хаах хүртэл Оюу Толгой нь хөдөлмөрийн менежмент, ажилчин хөлслөх, ажилд авах бодлогуудаа үргэлжлүүлэн хэрэгжүүлсээр байх болно. Ажилчин хөлслөх, ажилд авах, ажилчдын болон гэрээт гүйцэтгэгчдийн ажиллах нөхцөл, сургалт, ажлаас халах, цомхотгох зэрэг хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээнүүдийн талаар D17: *Хөдөлмөр Эрхлэлтийн Менежментийн Төлөвлөгөө* бүлэгт нарийвчилан тодорхойлсон.

### 9.2 ХАМРАХ ХҮРЭЭ

#### 9.2.1 Тодорхойлолт

Олон Улсын Санхүүгийн Корпорац (ОУСК)-ийн Гүйцэтгэлийн стандарт (ГС2) '*Хөдөлмөрийн ба ажлын байрны нөхцөл*', мөн Европийн Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-ны Гүйцэтгэлийн Шаардлага 2 (ГШ2) '*Хөдөлмөрийн ба ажлын байрны нөхцөл*'-д тодорхойлсноор хөдөлмөр эрхлэлтийн шууд болон шууд бус нөлөөллийг аль алиныг нь авч үзэх шаардлагатай. Уг үнэлгээнд дараах нэр томъёо, тодорхойлолтыг ашиглана:

- *Ажилчид* – Оюу Толгойн албан ёсны ажилчид (ажилтан/боловсон хүчин) орно
- *Гэрээт ажилчид* – төслийн гэрээт гүйцэтгэгчид болон бусад зуучлагчдаар дамжуулан төсөлд ажиллаж буй ажилчид, мөн Оюу Толгойн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой гол үүрэг, ажлыг тодорхой хугацаанд гүйцэтгэдэг ажилчид ;
- *Ханган нийлүүлэлтийн сүлжээ гэдэгт төсөлд бараа, үйлчилгээ нийлүүлэгчид орно.* Оюу Толгой нь ханган нийлүүлэгчдийн ажилд хөндлөнгөөс оролцох буюу шууд удирдахгүй боловч бодлого, үйл ажиллагаанд тавигдах шаардлагууд зэргээрээ нөлөөлөх боломжтой юм.<sup>1</sup>

<sup>1</sup> Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) –ийн зөвлөмж 1: Нийгэм, байгаль орчны тогтвортой байдлын талаарх Гүйцэтгэлийн Стандарт. Зөвлөмж 2 '*Хөдөлмөр эрхлэлт ба Ажлын нөхцөл*' [2007 оны 7 дугаар сар].

## 9.2.2 Орон зайн хамрах хүрээ

Энэхүү үнэлгээгээр Ханбогд сумын шууд болон шууд бус хөдөлмөр эрхлэлтийг Өмнөговь аймгийн хэмжээнд цаашлаад Өмнийн говийн бүс нутгийн түвшинд хамтад нь авч үзнэ. Төслийн цар хүрээ, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ шаардлагын урьдчилсан тооцоогоор хөдөлмөр эрхлэлтийн үр ашиг нь үндэсний болон олон улсын хэмжээнд мэдрэгдэх магадлалтай. Төслийн нийт ажиллах хүчний Монгол болон гадаад ажилчдын эзлэх хувийг Оюу Толгой төслийн ХӨОГ-нд тусгасан тусгай шаардлагаар тогтооно.

## 9.2.3 Цаг хугацааны хамрах хүрээ

Үнэлгээний цаг хугацааны хамрах хүрээ нь барилгын ажлын үе шат, уурхайн ажиллах 27 жил болон уурхайн хаалтын дараах шатуудыг хамрана.

## 9.3 НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

### 9.3.1 Нөлөөллийн тойм

Төслийн бүтээн байгуулалтын, ашиглалтын болон хаалтын шатанд хөдөлмөр эрхлэлтэд гарах нөлөөлөлийг дараах байдлаар тооцоолсон. Үүнд:

- Оюу Толгой болон төслийн гэрээт гүйцэтгэгчид шууд ажлын байр бий болгох;
- Оюу Толгойн ханган нийлүүлэлтийн сүлжээнд оролцож буй компаниуд шууд бус ажлын байр бий болгох.

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ болон үлдэх нөлөөллийн тоймыг энэ бүлгийн төгсгөлд хүснэгтээр харуулав (*Хүснэгт 9.2*).

### 9.3.2 Шууд хөдөлмөр эрхлэлт

#### *Нөлөөллийг тодорхойлох нь*

Барилгын үе дэхь Оюу Толгой төслийн нийт ажиллах хүч нь (нийт Оюу Толгой төслийн ажилчид болон гэрээт гүйцэтгэгч нарыг оруулаад) 2011 оны 12-р сарын байдлаар 14,800 хүрсэн бөгөөд энэ нь Оюу Толгой төслийг тухайн үедээ хамгийн том ажил олгогч болгосон юм. Ойролцоогоор 10,000 ажилчин буюу нийт ажиллах хүчний 67% нь Монгол улсын иргэд байна. Түүнчлэн Оюу Толгой нь нэмэлт 3300 монгол хүнийг сургалтанд хамруулан тэднээс ажилчид сонгон шалгаруулж авах бөгөөд энэ нь Монголын эдийн засагт сургагдсан боловсон хүчнээр хангаж байгаа юм. Барилга нь 3-н жилийн хугацаанд үргэлжилж 2012 оны 2 эсвэл 3-р улирал гэхэд дуусах төлөвлөгөөтэй байна (2009 оны дундаас эхэлсэн). Одоо ажиллах хүч нь буурч эхэлж байгаа.

Хүний нөөцийн газрын сар бүрийн ажиллах хүчний бүртгэлээр ажиллах хүчний тоо одоогоор буурч эхэлж байгаа бөгөөд өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах ажиллах хүчний хангалтай нөөцийг бүрдүүлж чадаж байгааг харуулж байгаа юм (хөдөлмөрийн хангамжтай холбоотой тулгарч буй бэрхшээлүүдийг урьдчилан тооцсон). Ажиллах хүчний оргил тоонд бүх ажилтнууд орж байгаа боловч оргил үед тэдний 500 хүн нь Улаанбаатар хотод (бүгдээрээ уурхай дээр байрладаггүй) байна. Одоогийн байдлаар ажиллах хүчний нийт тоо багасч байгаа учир компаний зүгээс ажиллах хүчний хангамжийн асуудлаар урьдчилан таамаглахгүй байгаа юм

Барилгын ажлын шат дуусах үед ажиллах хүчний эрэлт хэрэгцээ эрс буурна. Боловсон хүчний тоо бараг 70% (1-2 жилийн хугацаанд)-иар буурна. Ажиллах хүчний тоо ингэж огцом буурах нь төсөлд хөдөлмөр эрхэлж, төслийн эн тэргүүний ашиг шим болох орон нутаг болон бүс нутгийн хөдөлмөр эрхэлтэнд ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Төлөвлөсөн бүтээн байгуулалтын ажил дууссанаар зайлшгүй хийгдэх цомхотгол нь төслийн олон нийтийн дэмжлэгийг сулруулахад бас нөлөөлж болно.

Үйл ажиллагааны явцад ажиллах хүчний тоо жил бүр 3,000- 4,000 хооронд хэлбэлзэх бөгөөд ажилчдын 75-аас багагүй хувь нь Монгол ажилчид байна.<sup>2</sup>

Төслийн ашиглалтын хугацаа дуусахад ажил эрхлэлт үлэмж хэмжээгээр багасах бөгөөд аажимдаа ажил эрхлэх боломж бүрэн зогсох болно. Төслийн хаагдахад гарах үр дагаварыг тодорхой хугацаанд хянаж, энэ үе шатанд ойртохын хирээр давтан сургалт зохион байгуулах, давтан ажил эрхлэх боломж олгох зэрэг нарийвчилсн төлөвлөгөөг боловсруулна. Доорх Хүснэгт 9.1-д үзүүлснээр гадаад ажилчдын тоо цаашид аажмаар буурч 2020 гэхэд төслийн нийт ажиллах хүчний 3% орчим болох төлөвтэй байна<sup>3</sup>.

Оюу Толгой төслийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдлаас харахад маш олон тооны Монгол ажилчид, тэр дундаа Ханбогд сумын оршин суугчид төсөлд ажиллаж байна. 2010 оны эцсээр Ханбогд сумын<sup>4</sup> 629 хүн Оюу Толгойд болон гэрээт компаниудад ажиллаж байгаагаас, 346 нь эмэгтэй, 283 эрэгтэй хүмүүс байна (сумын нийт хүн ам 3,552 юм). Энэ нь тус сумын нийт хүн амын 18%, нийт хөдөлмөрийн насны хүн амын 31% нь ажилтай байгааг харуулж байна (Орон нутаг болон нийгмийн асуудал эрхэлсэн хэлтсийн 2010-2011 оны нийгмийн зураглалын мэдээллийн сангаас гаргасан тооцоогоор Ханбогд суманд хөдөлмөрийн насны 2,018 хүн байна). Ханбогд сумын 629 ажилчдын дийлэнх нь гэрээт гүйцэтгэгч компаниудад ажиллаж байна: 2011 оны 9-р сард 102 Ханбогд сумын оршин суугчид Оюу Толгойд шууд ажиллаж байгаа бөгөөд үүний 71 нь эрэгтэй, 31 нь эмэгтэй ажилчид байна. Эрэгтэй ажилчдын сарын дундаж цалин 438\$ бол эмэгтэй ажилчдын хувьд 453\$ байна.

Ханбогд сумын эмэгтэйчүүд Оюу Толгой болон гэрээт гүйцэтгэгч компаниудад хангамжийн болон захиргааны чиглэлийн ажлуудыг хийдэг. Өнөөгийн байдлаар эрэгтэйчүүд нь жолооч, биеийн хүчний ажил, хамгаалагч зэрэг ажлуудыг голдуу эрхэлж байна. Ханбогд сумын оршин суугчдын тодорхой хувь нь Оюу Толгойд мэргэжлээрээ ажиллаж байгаа юм. Мөн Улаанбаатар хотод Оюу Толгойн төв оффист эмэгтэйчүүд төрөл бүрийн мэргэжлээр ажилладаг.

#### Хүснэгт 9.1: Төслийн ажиллах хүчний тоо, 2009 - 2018\*

|                            | 2009                  | 2010  | 2011   | 2012   | 2013                 | 2014  | 2015  | 2016  | 2017  | 2018  |
|----------------------------|-----------------------|-------|--------|--------|----------------------|-------|-------|-------|-------|-------|
|                            | Барилгын ажлын үе шат |       |        |        | Үйлдвэрлэлийн үе шат |       |       |       |       |       |
| Монгол ажилчид             | 1,009                 | 4,331 | 11,722 | 6,184  | 3,533                | 2,903 | 3,116 | 3,168 | 3,218 | 3,230 |
| Гадаад ажилчид             | 170                   | 1,634 | 6,182  | 3,844  | 561                  | 477   | 389   | 319   | 324   | 326   |
| Нийт Ажиллах хүч           | 1,179                 | 5,964 | 17,904 | 10,028 | 4,094                | 3,378 | 3,506 | 3,487 | 3,542 | 3,556 |
| Монгол ажилчдын эзлэх хувь | 86%                   | 73%   | 65,5%  | 62%    | 86%                  | 86%   | 89%   | 91%   | 91%   | 91%   |

<sup>2</sup> Оюу Толгойн Хөрөнгө Оруулалтын Гэрээ, Заалт 8.5.2 'уурхайн болон уул уурхайн холбогдолтой ажил гүйцэтгэхээр бол ажиллагсадныхаа 75-аас доошгүй хувьд нь Монгол иргэдийг авч ажиллуулна.

<sup>3</sup> Оюу Толгойн Хөрөнгө Оруулалтын Гэрээ, Заалт 8.4 Ашигт малтмалын тухай хуулийн 43.1-д заасны дагуу Хөрөнгө оруулагч нь нийт ажиллагсдынхаа 90-ээс доошгүй хувьд нь Монгол улсын иргэд байна.

<sup>4</sup> Энэ үзүүлэлтэд Ханбогд сумын хүн ам орж байгаа бөгөөд Монгол улсын бусад газраас шилжин ирж Ханбогд суманд түр оршин суугаа хүмүүсийг тооцоогүй болно.

Эх сурвалж: Оюу Толгой төслийн ажиллах хүчний мэдээллийн санааас гаргасан тооцоо \*Тайлбар: Оюу Толгой нь өөрийн ажилчид болон төслийн гэрээт гүйцэтгэгчид, дэд гэрээт гүйцэтгэгчдийн мэдээллийг сар бүр шинэчилдэг. Оюу Толгойн Хүний нөөцийн хэлтсээс гаргасан 2011 оны мэдээ (2011 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн мэдээгээр).

Хэдийгээр Оюу Толгойн зүгээс ажил эрхлэх боломжийг хангалттай олгож байгаа ч орон нутгийн иргэд энэхүү боломжийг бүүрэн дүүрэн ашиглах чадвар, чадавхиар хязгаарлагдмал байна. Ханбогд суманд болон аймгийн хэмжээнд, ялангуяа хөдөө орон нутгийн хүмүүсийн хувьд төсөлд шаардлагатай ажлын ур чадварын болон ажлын туршлагын түвшин тааруухан байна. Даланзадгад, Улаанбаатар зэрэг хотоос ирсэн ажилчид илүү өндөр түвшний боловсролтой байдаг тул Оюу Толгой компанид илүү өндөр түвшний ур чадвар шаардсан ажил эрхлэх боломжтой байна.

Төслийн зорилтот сургалтад хамрагдахгүйгээр тухайн ажлын байранд тэнцэх, ажилд орсон хойноо гүйцэтгэл сайтай байж чадах боловсон хүчин ихэвчлэн хот суурин газар болон үйлдвэржсэн бүс нутгуудаас ирдэг. Энэхүү хязгаарлагдмал байдал нь Оюу Толгойн тавьсан Төслийн нөлөөллийн бүсэд амьдарч буй уугуул иргэдийн амьдралын түвшинг сайжруулна гэсэн зорилгод муугаар нөлөөлөөд зогсохгүй шилжин ирэгсэд болон орон нутгийн хүн амын хооронд зөрчил үүсгэх магадлалтай юм. Өргөн хүрээнд авч үзвэл Монгол улсад уул уурхайн салбарын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг (өөрөөр хэлбэл одоогийн болон цаашид төлөвлөсөн ашигт малтмалын төслүүдийг хамруулаад) бүрэн дүүрэн хангаж чадах ур чадвартай техникч, мэргэжлийн инженер, операторууд дутагдалтай байна. Ур чадвартай боловсон хүчний төлөөх өрсөлдөөн хүчтэй байгаа нь уул уурхайн мэргэжлээр төгсөгчдийн хувьд мэргэжлээрээ ажиллах боломж өндөр гэсэн үг юм.

Түүгээр ч барахгүй Монголын эмэгтэйчүүд ерөнхийдөө эрэгтэйчүүдийг (бага насандаа мал маллахад туслахаар сургуулиас гардаг) бодвол боловсролын түвшин илүү өндөр байдаг боловч эмэгтэйчүүдийн ажлын байранд гүйцэтгэх үүрэгт зарим хууль эрх зүйн саад бэрхшээл байна (Хөдөлмөрийн хуулийн хуулийн 101 зүйлийг харна уу).<sup>5</sup> Энэ хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэх шатанд явж байгаа бөгөөд улмаар эмэгтэйчүүд гүний уурхайд ажиллах, хүнд машин механизм жолоодох боломжтой болох юм.<sup>6</sup> Сүүлийн жилүүдэд Монгол улсад эмэгтэйчүүд орлого олох байдал нь өсөхийн хирээр гэр орны ажилтай зууралдалгүй, гадуур ажил хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдэд хандах хандлага орон нутгийн хэмжээнд өөрчлөгдөж байна.

### **Нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

Оюу Толгой энэ ур чадварын дутагдалтай байдлыг нөхөж, орон нутгийн иргэдийг ажилд авах явдлыг дэмжих, ажил эрхлэх тэгш байдлыг хангах зорилгоор хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлээд байгаа юм. Эдгээр арга хэмжээний талаар дор дурдав.

#### **Орон нутгийн буюу үндэсний хэмжээний ажил эрхлэлтийг дэмжих**

Оюу Толгой нь Монгол улсын Засгийн газартай байгуулсан ХӨОГ-ээрээ орон нутгаас ажиллах хүчийг түлхүү авах, хөдөлмөр эрхлэлтийн тэгш байдлыг хангах үүргийг хүлээсэн. Ялангуяа ХӨОГ-гээр Оюу Толгой хөдөлмөр эрхлэлтийн талаар дараах үүргүүдийг хүлээсэн:

- Барилгын ажлын үндсэн болон өргөтгөсөн шатанд барилгын ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж буй аж ахуйн нэгжүүдийн нийт ажиллагсдынх нь **60-аас доошгүй** хувьд нь Монгол Улсын иргэдийг авч ажиллуулах талаар Оюу Толгой өөрөөс шалтгаалах бүхнийг хийнэ;
- Уул уурхайн үйл ажиллагааны хувьд, гэрээт гүйцэтгэгч компаниудын ажилчдын **75-аас доошгүй** хувь нь Монгол улсын иргэд байна;
- Хөрөнгө оруулагч нь нийт ажиллагсдынхаа **90-ээс доошгүй** хувьд нь Монгол улсын иргэдийг авч ажиллуулна;

<sup>5</sup>Оюу Толгой төслийн Нийгэм, эдийн засагт нөлөөлөх байдлын Үнэлгээ, Эцсийн тайлан, 2009 оны 9 дүгээр сар. МУИС-ийн Эдийн засгийн сургууль, Бодлого судлалын төв, Хүн амын сургалт, судалгааны төв.

<sup>6</sup>Хөдөлмөрийн хуулийн 101 дүгээр зүйлд эмэгтэйчүүдийг хүнд ажил, хөдөлмөрт оролцуулахгүй байх тухай заасан. Энэхүү зүйлийг Монгол улсын засгийн газар эргэн харж, судалж байгаа боловч одоо хир үйлчилсээр байна.

- Хөрөнгө оруулагч нь Оюу Толгой төсөлд ажиллах Монгол Улсын иргэн инженер-техникийн ажилчдын тоог өрсөлдөөний зарчмаар аль болох нэмэгдүүлэх чармайлт гаргана. Тухайлбал, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлснээс хойш 5 жилийн дотор инженер-техникийн ажилтнуудын **50%-аас багагүй**, 10 жилийн дотор **70%-аас багагүй** хувь нь Монгол Улсын иргэд байх талаар бүхий л арга хэмжээг авна.

Оюу Толгой нь төслийн нөлөөллийн бүс нутаг болох Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумд цаашлаад Өмнийн Говийн бүс нутгийн бусад орон нутгийн оршин суугчдын ажил эрхлэлтийг нэн тэргүүнд авч үзнэ.

#### Ажиллах хүчний тооллого

Оюу Толгой төслийн ажилтан элсүүлэх журам, сургалт стратегийн дагуу Өмнөговь аймгийн хүн амын хөдөлмөрийн ур чадварын талаар тооллого хийсэн юм. Оюу Толгой Монгол улсын Мянганы Сорилын Сантай хамтран 2010 сүүлчээр дууссан энэхүү ажиллах хүчний тооллогыг санхүүжүүлсэн.

2010 оноос хойш Оюу Толгойн Хүний нөөцийн хэлтэс Төслийн нөлөөллийн бүсээр дамжуулан хөдөлмөрийн ур чадвар болон боломжийг үнэлсэн. *Хөдөлмөрийн ур чадварын судалгаа нь* байнга явагдах үйл явц бөгөөд ажил хайж буй орон нутгийн иргэд мэдээллийн санд мэдээллээ оруулах боломжийг олгож байна. Орон нутгийн иргэдийн боловсрол, сургалтанд хамрагдсан байдал, туршлага, хийхийг хүсч байгаа ажил зэргийн талаар мэдээллийг оруудаг. Орон нутаг болон нийгмийн асуудал эрхэлсэн хэлтэс нь сар бүрийн мэдээллийг Хүний Нөөцийн хэлтэс рүү дамжуулдаг бөгөөд CAML зэрэг гэрээт компаниуд орон нутагт ямар ур чадвартай иргэд байгаа талаар тэд судалдаг. Энэ нь Оюу Толгой болон түүний гэрээлэгчид орон нутгаас иргэдийг нэмж ажилд авахад нөлөөлсөн. Саяхан хийгдсэн судалгааны үр дүнг доор үзүүлэв. 2011 оны 11-р сарын сүүлийн байдлаар Оюу Толгой болон түүний гэрээт гүйцэтгэгчдэд 8,819 монгол ажилчид ажиллаж байна.

**Хүснэгт 9.2:** Хөдөлмөрийн ур чадварын судалгаа, 2011 оны 8-р сарын байдлаар (2010 оны 8-р сараас хойш)

| Сум         | Бүртгэгдсэн | Ажилд орсон |
|-------------|-------------|-------------|
| Ханбогд     | 155         | 27          |
| Манлай      | 164         | 119         |
| Баян-Овоо   | 94          | 32          |
| Даланзадгад | 468         | 34          |
| Нийт        | 881         | 212         |

2011 оны эцэс хүртэлх хөдөлмөр эрхлэлтийн тоон мэдээллийг доорх хүснэгтэнд харуулав.

**Хүснэгт 9.3:** 2011 оны 11-р сарын 30-ны байдлаар ажилд орсон хүмүүсийн тоог орон нутаг болон хүйсээр харуулав.

| Хүйс                               | Ханбогд | Баян-Овоо | Манлай | Даланзадгад | Өмнөговь | Бусад Монгол улсын нутаг дэвсгэр | Нийт  |
|------------------------------------|---------|-----------|--------|-------------|----------|----------------------------------|-------|
| Оюу Толгой, 2011 оны 11-р сарын 30 |         |           |        |             |          |                                  |       |
| Эрэгтэй                            | 83      | 5         | 8      | 74          | 20       | 789                              | 979   |
| Эмэгтэй                            | 34      | 1         | 2      | 29          | 6        | 424                              | 496   |
| Дэд дүн                            | 117     | 6         | 10     | 103         | 26       | 1,213                            | 1,475 |

| Бусад, 2011 оны 11-р сарын 30 |     |    |     |     |    |       |       |
|-------------------------------|-----|----|-----|-----|----|-------|-------|
| Эрэгтэй                       | 508 | 38 | 150 | 385 | 41 | 4,728 | 5,850 |
| Эмэгтэй                       | 254 | 5  | 71  | 248 | 8  | 908   | 1,494 |
| Дэд дүн                       | 762 | 43 | 221 | 633 | 49 | 5,636 | 7,344 |
| Нийт                          |     |    |     |     |    |       |       |
| Эрэгтэй                       | 591 | 43 | 158 | 459 | 61 | 5,517 | 6,829 |
| Эмэгтэй                       | 288 | 6  | 73  | 277 | 14 | 1,332 | 1,990 |
| Нийт                          | 879 | 49 | 231 | 736 | 75 | 6,849 | 8,819 |

Энэ ажлын үр дүнг дараах зорилгоор ашиглаж байна:

- Орон нутгийн ажиллах хүчийг Оюу Толгой төсөл болон Монгол улсад хэрэгжих бусад уул уурхайн болон үйлдвэрлэлийн төсөлд ажиллаж чадахуйц түвшинд ур чадварыг нь хөгжүүлэх арга замуудыг тодорхойлох;
- Сургалтын дутагдал болон хэрэгцээг олж тогтоох, Өмнөговь аймаг болон Монгол улсад байгаа техник мэргэжлийн сургалтын төвүүдийн сургалтын хөтөлбөр боловсруулах
- Оюу Толгойг сургалтын байгууллага, ТББ-ууд зэрэг олон түншлэгчтэй хамтран ажиллах, цаашлаад өргөн хүрээний сургалт болон ур чадвар дээшлүүлэх талаар арга хэмжээ авах, хэрэгжүүлэхэд чиглүүлэх

Хөдөлмөрийн ур чадварын судалгаанаас гарсан ур чадвар доогуур хүмүүсийн хувьд тэднийг дэмжих хөтөлбөр хэрэгжиж байгаа юм. Орон нутгийн иргэдийг ажилтай болох, эсвэл тэдний амьжиргааг дээшлүүлэхэд туслах чиглэлээр авч буй арга хэмжээний хүрээнд сургалтуудыг явуулж байгаа бөгөөд тэр талаар доорх хүснэгтэнд үзүүлэв. “Ажилд бэлэн болгох” мэргэжилтнүүдийг татан оролцуулж ур чадвар доогуур малчид болон мэргэжилгүй хүмүүст туслах төлөвлөгөөг боловсруулсан. 2011 оны 11-р сараас хойшхи Олон нутаг болон нийгмийн асуудал хариуцсан хэлтсийн тайлан болон тусгай техник мэргэжлийн сургалтуудын талаар дор танилцуулав.

**Хүснэгт 9.4:** Техникийн сургалтанд хамрагдсан оролцогчдын тоо (хуримтлагдсан)

| Сум         | Ногоо тарих | Эсгий хийх | Нарийн боов | Тогоочийн сургалт | Оёдол | Сүү боловсруулах болон эрүүл ахуй | Санхүү нягтлан бүртгэл | Ажлын байрны аюулгүй ажиллагаа | Нийт |
|-------------|-------------|------------|-------------|-------------------|-------|-----------------------------------|------------------------|--------------------------------|------|
| Ханбогд     | 8           | 7          | 2           | 1                 | 2     | 26                                | 16                     | 7                              | 69   |
| Даланзадгад |             |            | 2           | 2                 | 3     |                                   | 10                     |                                | 17   |
| Манлай      | 8           |            | 1           | 2                 |       | 8                                 | 5                      | 6                              | 30   |
| Баян-Овоо   | 11          |            | 2           | 1                 | 1     |                                   | 8                      |                                | 23   |
| Нийт        | 27          | 7          | 7           | 6                 | 6     | 34                                | 39                     | 13                             | 139  |

*Цалин, хөлсний түвшнийг тэгш байлгах*

Оюу Толгой нь ажилчдад олгож буй цалингийн хэмжээ нь Монгол улсын нөхцөл байдалд нийцэхүйц ижил тэгш, хангалттай хэмжээнд байх явдлыг хангах үүднээс хяналт шинжилгээ хийж байх бөгөөд Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагын үндсэн зарчим, ОУСК/ЕСБХБ-ны стандартын дагуу эрх тэгш, шударга байх болно.



*B1: Танилцуулга бүлэгт* тодорхойлсноор, Оюу Толгой төсөл хэрэгжих тохиолдолд 2020 гэхэд Монгол улсад цалингийн дундаж хэмжээ Оюу Толгой төсөл хэрэгжихгүй байх хувилбартай харьцуулахад 30%-иар өндөр байх төлөвтэй байна.<sup>7</sup> Оюу Толгой нь ажилчдад олгох цалингийн хэмжээг жилийн цалин болон жишиг судалгаанд үндэслэнэ.

#### *Мэргэжлийн сургалт*

ХӨОГ-ний 8.12 заалт ёсоор<sup>8</sup>, Оюу Толгой нь 2010-2014 онуудад хэрэгжих 5 жилийн сургалтын стратеги болон төлөвлөгөөг боловсруулаад байна. Уг төлөвлөгөөнд хэд хэдэн гол зорилтуудыг дэвшүүлэн тавьсан. Үүнд:

- Монгол ажилчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ингэснээр төсөлд байнгын ажлын байртай болох, ажлын байраа хадгалах боломжтой болгох;
- Мэргэжил боловсролгүй хүмүүст төсөлд ажил эрхлэх боломж олгох, мэргэжилтэн болж хөгжихөд нь туслах.

2010-2014 онуудад Оюу Толгойгоос Монгол улсын иргэдэд зориулан уул уурхайн салбарт ажиллах чадварыг хөгжүүлэх 2.8 сая цагийн сургалт явуулна. Үүнд дараах салбарын сургалтууд багтана:

- Оператор (850 хүн);
- Худалдааны ажилтан (700 хүн);
- Мэргэжилтнүүд, техникч (600 хүн); Захиргаа удирдлага (1,100 хүн).

2010 онд Монгол улс засгийн газарт энэхүү *5 жилийн Сургалтын стратеги, төлөвлөгөөг* өргөн барьж, батлуулсан юм. Уг төлөвлөгөөгөөр Оюу Толгой нь дараах салбаруудад ирэх таван жилд хамгийн багадаа **50 сая америк долларын** хөрөнгө оруулах үүрэг хүлээсэн:

- Сургалт, сургалтын хэрэгсэл, сургалтын тоног төхөөрөмж;
- Монгол улсад олон улсын институцийн түншлэлийг ашиглан мэргэжил үйлдвэрлэлийн болон мэргэжлийн сургалт, боловсролыг хөгжүүлэх;
- Сургалт явуулах загвар ;
- Сургалтын менежмент, зохицуулалт;
- Ажилтан хөгжүүлэх тусгай хөтөлбөр (оюутны тэтгэлэг, мэргэжил дээшлүүлэх курс гэх мэт).

Мөн энэхүү Сургалтын стратегийн дагуу Оюу Толгой нь Монгол улсын БСШУЯ-тай дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан:

- Таван жилийн хугацаанд 150-230 оюутанд сургалтын тэтгэлэг олгох;
- Одоо байгаа техник мэргэжлийн 5 коллежийг засварлан сайжруулах, Даланзадгад, Улаанбаатар хотод шинээр хоёр техник мэргэжлийн коллежийг байгуулах<sup>9</sup>;
- Жил тутам 3,300 Монгол ажилчдыг сургаж бэлтгэх шинэ ажилчдад зориулсан бүтцийг бий болгох.

---

<sup>7</sup> “Оюу Толгой зэс олборлох уурхай: Монгол улсын макро эдийн засагт үзүүлэх нөлөөллийг үнэлэх нь”, Эдийн засгийн сургууль, 2011 он.

<sup>8</sup> “Оюу Толгой төслийн сургалтын стратеги болон төлөвлөгөө нь Монгол Улсын уул уурхайн салбар, нэн ялангуяа Өмгийн Говийн бүс нутаг болон Оюу Толгой төсөлд шаардлагатай боловсон хүчин, техникийн, мэргэжлийн, нарийн мэргэшлийн мэдлэг ур чадварыг олгоход чиглэнэ”.

<sup>9</sup> Үүнийг хэрэгжүүлэхэд 50 сая долларын зардал гарна гэж тооцоолж байна. ОюуТолгой төслөөс 5 сая доллар гаргах бөгөөд эдгээр дэд бүтцийн санаачлагуудын талаар бусад уул уурхайн компани, үйлдвэрүүдтэй хамтран ажиллана.



Барилгын ажлын шатанд явагдсан сургалтын ихэнх нь Оюу Толгой төслийн ажилчдыг үйлдвэрлэлийн үе шатанд илүү сайн бэлтгэх зорилгоор тэдний ур чадварын түвшинг нэмэгдүүлэхэд чиглэж байсан. Төслийн үйлдвэрлэлийн шатанд ч Оюу Толгой нь Монгол ажилчдад зориулсан сургалтуудыг явуулсаар байх бөгөөд өмнө нь гадаад боловсон хүчний гүйцэтгэж байсан үйлдвэрлэлийн ажил руу монгол ажилчдыг үр дүнтэй шилжүүлэхэд бэлтгэнэ. Үүнд дараах зүйлс хамаарна:

- Оператор, худалдааны ажилтан, мэргэжилтэн болон техникийн ажилтнуудад зориулсан сургалтыг төрөл бүрийн хэлбэрээр явуулна. Үүнд анги танхимын, онлайн, ажлын байранд гэх мэт багтана. Дээр дурдсанаар, 2.8 сая цагийн сургалтыг анги танхимын хэлбэрээр олгоно;
- Оюу Толгой нь зэс олборлоход шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэх Рио Тинтогийн онлайн болон танхимд суурилсан уул уурхайн боловсролын модулийг ашиглах бүрэн бололцоотой болно;
- Оюу Толгой ажилчдынхаа мэргэжлийн ур чадвар, мэдлэг туршлагын түвшинг өнөөгийн бодит байдал болон шаардагдах ур чадварын түвшинтэй харьцуулан гаргах зорилго бүхий мэдээллийн санг ашиглан үнэлэнэ. Ингэснээр тусгай сургалтын хэрэгцээг тодорхойлох, мэргэшүүлэх сургалтыг явуулахад тус дөхөм болох юм;
- Их сургуулийн болон мэргэжлийн сургалтын бүх хөтөлбөрүүдэд Англи, Монгол хэлний хичээлүүд багтана. Одоогоор Монгол улсын уул уурхайн мэргэжилтэн бэлтгэгдэг томоохон их дээд сургууль, боловсролын байгууллагууд Оюу Толгой төсөлд төдийлөн хамааралтай бус сургалтын хөтөлбөрүүд ашиглаж байна (тухайлбал Орос стандарт, арга зүй ашиглаж байна);
- Англи хэл дээр суралцах нь Монгол ажилчдыг Рио Тинто группийн хэмжээнд гадаад улс руу томилогдон очих, солилцооны хөтөлбөрт хамрагдах боломжтой болгох юм. Оюу Толгой нь хилийн чанадад Рио Тинто группийн уул уурхайн төслүүд дээр томилогдон очиж ажиллах боломжийг ажилчид болон төгсөгчдөд олгоно.

#### *Орон нутгийн ажилчдад зориулсан сургалт*

Оюу Толгой төсөл нь орон нутгийн ажилчдад дамжих гүүр болох/ажилд бэлтгэгдэх сургалтын багцыг боловсруулахаар Рио Тинтотой хамтран ажиллаж байна. Уг сургалтын хөтөлбөр 2011 оны эхээр эхэлсэн бөгөөд Төслийн нөлөөллийн бүс дэх орон нутгийн иргэд, оршин суугчдыг үйлдвэрлэлийн түвшинд ажил эрхлэх, цаашлаад бусад ажилд шилжин ажиллахад бэлтгэхэд чиглэгдсэн юм.

Оюу Толгойн үүсгэн байгуулж цаашид удирдах **Ханбогд сумын Мэргэжлийн Сургалт, Үйлдвэрлэлийн Төвийн** мэргэжлийн сургалтад хамрагдах давуу эрхийг Ханбогд сум болон бусад Өмнийн Говийн оршин суугчдад олгоно. Энэ төв 2012 оноос үйл ажиллагаагаа эхлүүлэх ба орон нутгийн ажилчдыг сургалтад хамрагдах боломжийг ихээр нэмэгдүүлэх зорилготой.

#### *Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт*

Одоо мөрдөгдөж буй Монгол улсын Хөдөлмөрийн хуулиар эмэгтэй хүнийг эрхлэхийг хориглосон ажлуудын төрлүүд байгаа бөгөөд энэ нь Оюу Толгой болон түүний гэрээт гүйцэтгэгчдэд ажилд орох эмэгтэйчүүдэд нөлөөлж болох юм. (Хөдөлмөрийн хуулийн 101-р зүйл).<sup>10</sup> Хэдийгээр энэхүү хуулийг хянаж үзэж байгаа боловч одоогийн хязгаарлалтын хүрээнд Оюу Толгой ажилтан авах, хөдөлмөр эрхлэлтийн стратегиа мөрдөн ажиллаж байгаа юм. Энэхүү хуулийн саад тотгороос гадна, монгол эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдийхээс өндөр байдаг (хөвгүүдийг бага насанд нь сургуулиас нь гаргаж мал маллуулдаг). Тийм учраас Оюу Толгойн хувьд энэ нь тулгамдсан асуудал нөөц юм. Гэрээс гадуур хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдэд хандах орон

<sup>10</sup> Оюу Толгой төслийн Нийгэм-эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ, Эцсийн тайлан, 2009 оны 9-р сар, Бодлого судлалын төв, Монгол улсын Их сургуулийн Эдийн засгийн сургуулийн Хүн амын сургалт, судалгааны төв,

нутгийн иргэдийн хандлага сүүлийн жилүүдэд өөрчлөгдөж байгаагийн учир нь ихэнх эмэгтэйчүүд өрхийг тэжээх орлого олдог болсонтой холбоотой.

Одоогийн байдлаар Ханбогд сумын эмэгтэйчүүд Оюу Толгой болон түүний гэрээт гүйцэтгэгчдийн кэмпиин гал тогоонд хоол бэлтгэх, түүнчлэн захиргааны ажил эрхэлж байна. Ханбогд сумын нилээд олон тооны эмэгтэй оршин суугчид Оюу Толгойд мэргэжлийн ажлаа хийж байна. Оюу Толгойн Улаанбаатар хотын оффист эмэгтэйчүүд багийн ахлагч, сахилгын удирдагч зэрэг янз бүрийн мэргэжлээрээ ажилладаг. Ямарваа нэгэн хөдөлмөр эрхлэлтийн саад бэрхшэлийг арилгахад чиглэсэн саяханы явуулсан судалгаагаар одоогийн байдлаар Ханбогд суманд зохион байгуулагдаж буй ажлын байранд бэлтгэх сургалтанд хамрагдсан 114 хүн байгаа бөгөөд тэдний 79% нь эмэгтэйчүүд үлдсэн 21% нь эрэгтэйчүүд байгаа юм. Оюу Толгойн ажиллах хүчний гол цөм нь эмэгтэйчүүд бөгөөд эмэгтэйчүүдийг ажилд авах талаар хүчин чармайлт тавин ажиллаж байна. Энэхүү зорилт нь Хөдөлмөрийн хуулийн хязгаарлалтыг харгазан үзэлгүйгээр өрхийн шаардлагыг тэнцвэржүүлэх, хүүхэд асрах, болон бусад өрхийн ажлаас чөлөөлж ажилд эмэгтэйчүүдийг ажил хөдөлмөр эрхлэхэд чиглэгдэж байна.

#### *Цомхотгох, ажлаас халах*

Оюу Толгой нь Монгол улсын Хөдөлмөрийн хуулийн дагуу ажилчдыг цомхотгох бодлого, журмыг боловсруулаад байна. Бүтээн байгуулалтын ажил дууссанаар ажилчдыг цөөлөх, халах зайлшгүй шаардлага гарах ба үүнтэй холбоотой дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ:

- Орон нутгийн (Төслийн нөлөөллийн бүс) болон бүс нутгийн (Өмнийн Говьг) барилгын ажлын шатанд ажилласан ажилчдыг эн тэргүүнд үйлдвэрлэлийн ажилд оролцуулах, тэднийг барилгын ажлаас үйлдвэрлэлийн ажилд шилжихэд шаардагдах сургалтаар хангана;
- Одоогийг байдлаар уурхайн барилгын ажилд оролцож буй ажиллах хүчийг цаашид Оюу Толгой ханган нийлүүлэгчид, үйлчилгээ эрхлэгчид, Ханбогд суманд үйлдвэрлэлийн үе шатны ажиллах хүчийг орон сууцжуулах барилгын компаниудыг санхүүжүүлж, удирдаж буй бүс нутгийн дэд бүтцийн болон хөгжлийн төслүүдэд дахин ажиллууж, тараан байршуулна;
- Оюу Толгой нь ЕСБХБ-ны ГШ 2–д тодорхойлсончлон ажилчдыг бөөнөөр ажлаас халах явдлаас зайлсхийнэ. Мөн Оюу Толгой нь барилгын ажил гүйцэтгэж буй гэрээт компаниуддаа Монгол ажилтнуудынхаа шилжилт хөдөлгөөнийг зөв зохистой удирдах, давхар гэрээт гүйцэтгэгчид ажилчдыг бөөнөөр нь ажлаас халахгүй байх, олон тооны ажилчдыг нэгэн зэрэг цомхотголд оруулахгүй байх зэрэг шаардлагуудыг тавина;
- Цомхотгох зайлшгүй шаардлагатай тохиолдолд урьдчилан мэдэгдэх хугацаа, зөвлөлдөх нөхцөл, халагдсаны нөхөн төлбөрийг олгохдоо Монгол улсын Хөдөлмөрийн Хууль болон ОУСК-ийн ГС 2, ЕСБХБ-ны ГШ 2 – ын шаардлагыг дагаж мөрдөнө;
- Ажлаас халахдаа уурхай дээрт дээр ажилласан барилгын ажилчдыг ирсэн газарт нь буцаах тээвэрлэлтийн асуудлыг зохицуулна. Ингэснээр тэднийг тэр хавийн газар нутагт өөр ажил хайж, уурхай орчимд болон орон нутагт үлдэхээс сэргийлнэ;
- Бүх гэрээт хятад ажилчдын ажиллах гэрээ дуусмагц дахин шинээр ажиллуулах, өөр ажилд шилжүүлэх, эсвэл буцаах арга хэмжээ авна. Оюу Толгой төсөлд ажиллаж буй Хятад улсын гэрээт гүйцэтгэгчид Монгол улсын иргэдийг, ялангуяа мэргэжилгүй буюу хагас мэргэжлийн ажилчдыг авч ажиллуулна. Энэ тохиолдолд Монгол ажилчид улс дотроо ажиллах бөгөөд, гэрээний стандарт журмын дагуу уурхайн сайт дээр шилжүүлэн ажиллуулна.

Төсөл олон жил үргэлжлэн хэрэгжих тул /уурхайн үйл ажиллагааны 27 жил/ уурхайн ашиглалтын хугацаа дуусах үед үйлдвэрлэлийн ажилд оролцсон Монгол ажилчид тухайн орон нутгийн иргэдийн нэг хэсэг болсон байх ба орон сууцны хөтөлбөр хэрэгжсэнээр тэднийг Ханбогд суманд өөрийн орон байртай болоход тус дөхөм болох юм. Ханбогд сум, Өмнөговь аймгийн хэмжээнд эдийн засгийн өсөлтийг дэмжсэнээр цалинтай хөдөлмөр эрхлэх боломж, орлого олох эх үүсвэр ихээр нэмэгдэх, ингэснээр уурхайг хаах үеийн сөрөг нөлөөллийг бууруулахад тусална.

#### *Эмэгтэй ажилчдад дэмжлэг үзүүлэх*

Оюу Толгойн ‘Ажилтан ажилд авах бодлого, журам’ –аар төсөл болон гэрээт гүйцэтгэгч компаниудын аль алинд нь эмэгтэй хүмүүсийг авч ажиллуулах, тэднийг сургаж бэлтгэх явдлыг дэмждэг. Оюу Толгой нь сургалтын хөтөлбөрөөрөө (бизнесийн ур чадварын сургалт) дамжуулан эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг дэмжихийн тулд орон нутгийн холбогдох ТББ-уудтай хамтран

ажиллаж, эмэгтэйчүүд толгойлон ажилладаг орон нутгийн бизнесийн байгууллагуудтай хамтран ажиллах арга замыг эрэлхийлнэ (тухайлбал орон нутгийн хоршооллууд).

Оюу Толгойн *Орон нутгийн бизнес, эдийн засгийг хөгжүүлэх (ОНБЭЗХ)*, *Орон нутгийн ханган нийлүүлэгчдийг хөгжүүлэх санаачлагын* нэг хэсэг болгон орон нутгийн бизнесийн байгууллагуудад зориулан сургалт хийх зэргээр дэмжлэг үзүүлж ажиллах бөгөөд уул уурхайн үйл ажиллагаанд шаардлагатай бараа, үйлчилгээний эрэлт хэрэгцээ нэмэгдсэнээр орон нутагт бизнесийн хүрээ өргөжин хөгжих юм. Оюу Толгой нь дээр дурдагдсан хөтөлбөрүүдийн хүрээнд орон нутгийн бизнесийн байгууллагууд болон ханган нийлүүлэгчид эмэгтэйчүүдийг авч ажиллуулах явдлыг дэмжинэ.

### **Нөлөөллийн зэрэглэл**

Барилгын болон үйлдвэрлэлийн шатны аль алинд нь Оюу Толгой төсөл нь Төслийн нөлөөллийн бүс, Өмнийн говийн бүс нутаг болон Монгол **улсын хэмжээнд** ажил эрхлэлтэд ихээхэн **эерэг** нөлөөлөл үзүүлнэ. Монгол улсын иргэдэд болон орон нутгийн ард иргэдэд ажил хөдөлмөр эрхлэх **бодит** боломжууд ихээр бий болоод байгаа юм. Ажилд томилох, хөдөлмөр эрхлэхэд давуу эрх олгох журмыг үргэлжлүүлэн мөрдсөнөөр, Монгол ажилчдад зориулсан сургалтыг ХӨОГ-нд заагдсаны дагуу зохион байгуулснаар, мөн дээрх бүлэгт дурдсан Сургалтын стратеги, төлөвлөгөөг хэрэгжүүлснээр шууд ажил эрхлэлтийн ашиг тус нь **дунд хугацааны** буюу хамгийн багадаа л гэхэд уурхайн нийт хугацааны туршид мэдрэгдэж байх болно.

Төсөл нь уурхайн хаалтын болон бүр мөсөн хаагдах шат руу ойртохын хирээр ажиллах хүчний хэрэгцээ шаардлага огцом буурна. Оюу Толгой Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан, бөөнөөр цомхотгохоос зайлсхийж, ажилчдыг аажим аажмаар чөлөөлөх бодлого барих бөгөөд ажиллах шаардлагагүй болсон ажилчдыг давтан сургах зэргээр дэмжиж ажиллах юм. Цомхотгох шаардлага гарах нь **гарцаагүй** бөгөөд энэ сумын иргэдийн орлогын түвшинд **их сөрөг нөлөөлөл** үзүүлэх магадлал **маш өндөр** байна. Уурхайн хаалтын болон цомхотголын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах, боломжтой бол ажиллах хүчийг дахин тараан байрлуулах зэргээр эдгээр сөрөг нөлөөллийг бууруулна. Гэвч үр дүн нь **дунд хугацааны** байх төлөвтэй.

### **9.3.3 Шууд бус хөдөлмөр эрхлэлт**

#### **Нөлөөллийг тодорхойлох нь**

Оюу Толгой болон түүний гэрээт гүйцэтгэгчдэд үйлдвэрлэлийн өдөр тутмын хэрэгцээ болон ажилчдын дотоод хэрэгцээг хангах зорилгоор олон тооны худалдаа эрхлэгчид, ханган нийлүүлэгчид, үйлчилгээ эрхлэгчидтэй хамтран ажиллах шаардлага гарна. Оюу Толгой, түүний гэрээт компаниуд бүтээн байгуулалтын ажлын эхэн үед хоол хүнс, угаалга, машин, тээврийн үйлчилгээний нийлүүлэлт, хоол хүнсний материалын нийлүүлэлт, эргүүл хамгаалалтын үйлчилгээ, мөн барилгын зарим тоног төхөөрөмж зэрэг олон тооны бараа, үйлчилгээг Монгол улсаас худалдан авсаар байна.

Үүнээс гадна төслийн нөлөөллийн бүсийн гаднаас хүн ам ихээр шилжин ирж орон сууц, хоол хүнс, бусад төрлийн нөөц, үйлчилгээний хэрэгцээ ихээхэн нэмэгдсэнээр эдийн засгийн хоёрдогч гуравдагч үйл ажиллагаанууд идэвхжих юм.

Төсөл болон холбогдох үйл ажиллагаануудыг орон нутгийн бараа, үйлчилгээгээр (тухайлбал бетон зуурмаг, элс, бетон, барилгын материал, модон материал, тоног төхөөрөмж түрээслэх, хоол хүнс, тээврийн үйлчилгээ зэрэг) хангах боломж гарна. Эдгээрийн ихэнхийг нь, тухайлбал машин техник, материал зэргийг ханган нийлүүлэлт, худалдан авалтын гэрээгээр хийх бөгөөд харин бусад зүйлсийг нь холбогдох албан тушаалтны /барилгын кемпийн хоол хүнсний хангамж хариуцсан менежер гэх мэт/ худалдан авах стратеги, шийдвэрт үндэслэн худалдан авах юм.

Төсөлд нийлүүлэх бараа, үйлчилгээ, нөөцөд дараах зүйлс орно:

- Уурхайн барилгажилт, үйлдвэрлэл, хаалт, туслах байгууламжтай холбоотой ажлыг хэрэгжүүлэх, нийлүүлэлт хийх ;
- Төсөлд тээврийн болон хадгалах үйлчилгээ үзүүлэх ;

- Хоол хүнсний хангамж, нийлүүлэлт, цэвэрлэх үйлчилгээ;
- Барилгын болон туслах материал нийлүүлэх, инженерийн, суурилуулах, засварлах үйлчилгээ;
- Цагаан хэрэгсэл, цахилгаан хэрэгсэл, харилцаа холбоо болон хэмжих тоног төхөөрөмж нийлүүлэх;
- Харуул хамгаалалт;
- Байр сууц, угаалга, хувцас;
- Жижиглэн худалдаа;
- Бензин шатахуун
- Амралт, урлаг соёлын үйлчилгээ

Ерөнхийдөө уул уурхайн төслөөс нэг ажлын байр бий болох бүрт үйлчилгээ, хангамжийн салбарт 1.5-2.5 ажлын байр бий болдог<sup>11</sup>. Энэ нь орон нутгийн болон бүс нутгийн түвшинд орон нутгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдийн сонирхлыг нэмэгдүүлээд зогсохгүй хөнгөн үйлдвэр (тухайлбал механикжуулалт) болон жижиглэн худалдаа, зочид буудал, тээвэр зэрэг үйлчилгээний өсөлтийг бий болгодог юм.

Үндэсний хэмжээнд төсөлд шаардлагатай машин техник, барилгын тоног төхөөрөмж, бензин шатахуун зэрэг бараа, үйлчилгээг үндэсний компаниуд ханган нийлүүлж байна. 2010 оны 1 дүгээр сарын 1-нээс 8 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл Оюу Толгой үндэсний компаниудтай нийт 206 сая ам.долларын үнийн дүн бүхий 98-н гэрээнд гарын үсэг зуржээ. Эдгээр гэрээнүүдийн нилээдийг орон нутгийн болон бүс нутгийн ханган нийлүүлэгчидтэй хийсэн байна<sup>12</sup>.

Оюу Толгой төслийг дагаж төслийн нөлөөллийн бүсэд хүн ам ихээр шилжин ирж байгаа нь орон нутгийн бизнест нөлөө үзүүлж, нөөц, бараа, үйлчилгээний эрэлт хэрэгцээ улам бүр нэмэгдэж ашиг олох боломж бүрдэнэ. Жижиг дунд аж ахуйн нэгжүүд, ялангуяа байр сууц, хоол хүнсний үйлчилгээ эрхлэгчид, бусад дотоодын худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд энэхүү хүн амын өсөлтөөс ашиг олох магадлалтай. Хүн ам ихээр нэмэгдэж эрэлт хэрэгцээ өссөнөөр Өмнөговь аймаг, Өмнийн Говийн бүс нутаг, бусад аймгуудын бизнесийн байгууллагууд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ явуулах, бизнес эрхлэх зорилгоор тус сум руу ирнэ гэж тооцоолж байна. Эдгээр бизнесүүдэд шаардагдах ажиллах хүчний тоо бага хэмжээгээр боловч тогтвортой нэмэгдэх тул цаашид ажил хөдөлмөр эрхлэх боломж сумын хэмжээнд илүү сайжрах юм.

Хэдийгээр төрөл бүрийн бараа, үйлчилгээний эрэлт хэрэгцээ нэмэгдсэнээр бизнесийн бааз суурь өргөжиж, нэр төрөл нь нэмэгдэх ч гэсэн Ханбогд болон Даланзадгад сумдын орон нутгийн бизнесийн байгууллагуудад бараа, үйлчилгээний тоо хэмжээ, чанар, олдоцын хувьд Төслийн эрэлт хэрэгцээг хангах чадавч одоогоор байхгүй байна. Иймд орон нутгийн худалдаа, аж ахуй эрхлэгчид чанартай, найдвартай ханган нийлүүлэлт санал болгож чадах хүртэл бараа, үйлчилгээний тодорхой хувийг Улаанбаатар хот болон Монгол улсын бусад газраас авах эсвэл Хятад болон бусад улс орноос импортоор авах хэрэгтэй болно.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нийлүүлэхэд бэрхшээл тулгарч байгаа нь үүний нэг жишээ юм. Оюу Толгой төсөлд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ ихээр гарч байна. Гэвч орон нутгийн хөдөө аж ахуйн салбар бага хэмжээтэй бөгөөд орон нутгаас худалдан авч болох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний ихэнх нь хөдөө аж ахуйн гол нэрийн хэдхэн бүтээгдэхүүн байдаг (өөрөөр хэлбэл голчлон мах, сүү, багахан хэмжээний тариа ургацаар хязгаарлагдана). Одоогийн эрэлт хэрэгцээг хангалттай хангахад үйлдвэрлэлийн зэрэгцээ орон нутгийн хөдөө аж ахуйн практик, технологийг

<sup>11</sup>Энэ тоог бусад уул уурхайн төслийн олон улсын туршлагад үндэслэн тооцож гаргасан болно; Уул уурхай, металын олон улсын зөвлөлөөс гаргасан хэвлэлд (2006) нийтэлснээр нийт шууд болон шууд бус хөдөлмөр эрхлэлтэнд эзлэх зайлшгүй үүсэх хадалмар эрхлэлтийн хувь 165-250 хооронд хэлбэлздэг.

<sup>12</sup>ОюуТолгойн Хангамжийн хэлтсийн мэдээ, 2011.

сайжруулах хэрэгтэй бөгөөд энэ ажлыг мэдээж богино хугацаанд хэрэгжүүлэх боломжгүй юм. Гэсэн хэдий ч төслийн үйлдвэрлэлийн хэрэгцээг хангахын тулд хөдөө аж ахуйн салбарыг урт хугацаанд хөгжүүлэх боломж байна.

### **Нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

*Оюу Толгойн Худалдан авалтын зарчмууд болон бодлогууд*

*Оюу Толгойн Худалдан авалтын зарчмууд болон бодлогууд нь Оюу Толгойн зүгээс төслийн худалдан авалтын үндэсний болон Өмнийн говийн бүс нутгийг чухалчлан үзэх амлалт үүрэг юм. Уг санаачлагыг Монгол Улсын Засгийн Газартай байгуулсан ХөОГ-ний дагуу биелүүлэх нөхцлүүдтэй уялдуулан ийнхүү тодорхойлсон:*

**4.12-р зүйл**– *“Хөрөнгө оруулагч нь Оюу Толгой төсөлд бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх чиглэлтэй орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих, үйл ажиллагааг нь эхлүүлэх, Монголын талын бизнесийн түншүүддээ Оюу Толгой төслөөс бүрэн хамааралгүйгээр хөгжих боломж олгох зорилгоор өргөжүүлэх, үйл ажиллагааных нь чиглэл, түншлэлийг олшруулах, бизнесийг нь хөгжүүлэх тусгай хөтөлбөрүүдийг дэмжинэ.”*

**9.9-р зүйл**– *“Хөрөнгө оруулагч нь бүс нутгийн хөгжилд хангалттай тусалцаа үзүүлнэ, мөн орон нутагт дэмжлэг үзүүлэхээс гадна шинэ бизнес, ажлын байр бий болгоход тусална.”*

*Ханган нийлүүлэгчдийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр*

Энэхүү бодлого нь Оюу Толгойн зүгээс үндэсний ханган нийлүүлэгчтэй хамтран ажиллах болон хөгжүүлэх үүрэг амлалтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн юм. Оюу Толгойг доорх 2 зорилгод хүрэхэд энэхүү бодлого туслана. Үүнд:

- Орон нутгийн ханган нийлүүлэгчдийн хөгжил болон зохион байгуулах асуудалдтай холбоотой Монгол улсын Засгийн газартай байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээний үүргээ биелүүлэх;
- Монгол нутаг дэвсгэрт Оюу Толгой уул уурхайн тавигдах шаардлагад тохирсон урт хугацааны, тогтвортой, орон нутгийн шинжтэй нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэхэд чиглэсэн дэмжлэг үзүүлэх. ;

Үндэсний ханган нийлүүлэгч ангилалд багтахын тулд дараах шаардлагуудыг тавина. Үүнд:

- Монгол улсын бүртгэлтэй компани;
- Нэмүү өртгийн албан татвар (НӨАТ) болон Монгол улсын хуулийн дагуу бусад хобогдох татварыг төлөх;
- Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр банкны гүйлгээ хийх. ;

Өмнийн Говийн ханган нийлүүлэгчдтэй харьцуулахад үндэсний ханган нийлүүлэгчид нь нилээд хөгжсөн байдаг боловч нөөцийн салбарын тавигдах шаардлага болон хүлээлтийг сайн мэддэггүйтэй холбоотойгоор ихэнх тохиолдолд Оюу Толгойн зарлаж буй өрсөлдөөнтэй тендерт тэд идэвхтэй оролцож чаддаггүй. Энэхүү бодлого нь эдгээр асуудлыг гарган тавьж, ханган нийлүүлэгчид Оюу Толгойн тендерт оролцоход нь Оюу Толгой тусламж дэмждэг үзүүлэхэд чиглэдэг.

Монгол улс дахь үндэсний ханган нийлүүлэгчдийн өсөлт хөгжилтийг чиглүүлэхэд Оюу Толгой дараах хэрэгслүүдийг ашиглаж байна. Үүнд:

- Оюу Толгойн гэрээний сонгон шалгаруулалтанд үр дүнтэй оролцох боломжийг хангах нийлүүлэгчдэд олгохын тулд мэргэжлийн дэмжлэг тусалцаа үзүүлэх, чадавхыг сайжруулах;
- Оюу Толгойн хэрэгцээг хангасан үйлчилгээг үзүүлэхийн тулд ханган нийлүүлэгчдэд зарцуулалтын төлөвлөгөөг ид тод болгох;
- Төслийн тендерт амжилттай оролцож чадаагүй ханган нийлүүлэгчдтэй эргэн холбогдож санал хүсэлтийг нь сонсоно. Ингэснээр ижил төстэй шаардлага тавигдаж байгаа дараагийн



тендэрт ханган нийлүүлэгчдийг аль чиглэлээр сайжруулах шаардлагатай талаар хэлж тэд илүү өрсөлдөх чадвартай болно;

- 20,000 ам.доллараас дээш үнэтэй бүх бараа эсвэл үйлчилгээг Өрсөлдөөнд тендэрээр шалгаруулна. Энэхүү өрсөлдөөнт тендэр нь үндэсний ханган нийлүүлэлтийн хөгжлийг чиглүүлж; ханган нийлүүлэгчдийн олон талт хөгжлийг дэмжих; Монгол улс даяар хөрөнгийг тэгш хуваарилах болон Монголын компаниудын ханган нийлүүлэлтийн сүлжээний өрсөлдөх чадварыг хөгжүүлэх.
- Оюу Толгойн ханган нийлүүлэгчдийг дэмжих хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд гол ханган нийлүүлэгчдийн үр ашигтай байдал, гэрээний дагуу хүлээсэн үүргээ сайн биелүүлснийг Оюу Толгой үнэлж шагнадаг
- Оюу Толгойн Үндэсний ханган нийлүүлэгчдийн зарцуулалтын ангилал бүрийн чиглэлийг тодорхойлно. Бүх чиглэлүүдийн талаар жил бүр олон нийтэд зарлах бөгөөд Оюу Толгойн худалдан авалтын цахим хуудсанд тавина. Өрсөлдөөнийг дэмжихийн тулд үндэсний ханган нийлүүлэгчдийн хувьд аливаа нэг худалдан авалтын чиглэл нь 80%-аас дээш байхгүй
- Оюу Толгойн дотоодын ханган нийлүүлэгчтэй хийх Мастер үйлчилгээний гэрээг боловсруулснаар тэдгээр нь зөвхөн ганц удаагийн тендэрт үргэлжлэн оролцох шаардлагагүй юм. Ингэснээр дотоодын ханган нийлүүлэгчдийн хөрөнгө оруулалт болон бизнесээ өргөжүүлэхэд нь туслах юм.
- Оюу Толгой нь орон нутгийн ханган нийлүүлэгчдийг хялбаршуулсан тавигдах шаардлагыг тавина. 100,000-аас дээш ам.долларын үйлчилгээ болон 10,000,000 ам.доллараас дээшхи барилгын үйлчилгээнд олон улсын стандартын дагуух тавигдах шаардлагыг баримтлана.
- Бүх зүйл нь ижил тохиолдолд давуу эрхийн нөхцөл. 2 буюу түүнээс дээш дендэрт оролцогчид нь техникийн хувьд хангалттай, бүх бүрэлдэхүүн хэсгүүд нь ижил гэхдээ бага зэргийн үнийн зөрөөтэй тохиолдолд олон улсын ханган нийлүүлэгчдээс илүү дотоодын ханган нийлүүлэгчдийг эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон байгаль орчны шаардлагуудыг хэрхэн хангалттай мөрдөж байгаад үндэслэн сонгоно.
- Доорхи нөхцөл байдлыг үндэслэн тендэрийн үнэнд засвар оруулах боломжийг дотоодын ханган нийлүүлэгчдэд олгоно.
  - Хэрэв тендэр нь 100,000 ам.доллараас дээш бол;
  - Хэрэв бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээ нь техникийн хувьд хангалттай бол
  - Хэрэв олон улсын болон дотоодын ханган нийлүүлэгчдийн хоорондын үнийн зөрүү нь 10% дотор байвал

#### *Өмнийн Говийн ханган нийлүүлэгчийн хөгжлийн бодлого*

Энэхүү бодлого нь Оюу Толгойн Өмнийн Говь гэсэн тодорхойлолтоор ангилагдсан ханган нийлүүлэгчтэй хамгийн түрүүнд хамтарч ажиллах үүрэг амлалтыг биелүүлэхэд чиглэгдсэн.

Энэхүү бодлого нь Оюу Толгойн дараах хоёр зорилгыг хэрэгжүүлэхэд туслана. Үүнд:

- Орон нутгийн ханган нийлүүлэгчдийн хөгжил ялангуяа Өмнийн Говийн бүс орчмын үйл ажиллагаа болон зохион байгуулах асуудалдтай холбоотой Монгол улсын Засгийн газартай байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээний үүргээ биелүүлэх;
- Ойролцоох бүс нутаг дахь Оюу Толгой уул уурхайн тавигдах шаардлагад тохирсон урт хугацааны, тогтвортой, орон нутгийн шинжтэй нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэхэд чиглэсэн дэмжлэг үзүүлэх;

Энэ бодлогын зорилго нь Өмнийн Говийн ханган нийлүүлэгч гэдэгт Өмнөговь аймагт үйлчилгээ эсвэл бүтээгдэхүүн нийлүүлж байгаа ханган нийлүүлэгчийг ойлгоно. Энэхүү тодорхойлолт нь Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуультай нийцдэг бөгөөд энэ хуулинд Монголд үйлдвэрлэгдсэн бараа бүтээгдэхүүнийг “...

гарал үүсэл нь Монголоос олдсон, тарьсан, ургуулсан, үйлдвэрлэсэн, боловсруулсан эсвэл Монголд үйлдвэрлэсэн, эсвэл үзүүлэлт, зорилго, хэрэглээ, тэдгээрийн ихэнх хэсгийг нь Монголд угсарсан, өөрчлөн шинэчилсэн” гэж тодорхойлсон байдаг.

Эдгээр ханган нийлүүлэгчид нь бүтээгдэхүүнийг өөрсдөө үйлдвэрлэдэг эсвэл Өмнийн Говийн ханган нийлүүлэгчдэд тавигдах шаардлагуудад нийцсэн үйлчилгээг үзүүлж чадаж байвал энэхүү бодлогод тусгасан дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт оролцох боломжтой болно. Энэхүү бодлогыг тодорхой болгохын тулд Өмнийн Говийн бүсэд байрлаж байгаа худалдааны компаниудад онцгой эрх олгоно.

Өмнийн Говийн ханган нийлүүлэгч гэсэн ангилалд орох болзлыг хангахын тулд аж ахуйн нэгж нь:

- Өмнийн Говийн бүртгэлтэй компани;
- Нэмүү өртгийн албан татвар болон Монгол улсын хуулиар бусад холбогдох татваруудыг төлөх;
- Нийт ажиллах хүчний Монго ажилчдын 75-аас дээш хувь нь Өмнөговь аймагт байрласан байх;
- Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр гүйлгээ хийх;
- Өөрсдийн бизнесийн төв/болон салбар оффисуудыг Өмнөговь аймагт бүртгүүлж Оюу Толгой нь эдгээр оффисоор дамжуулан үйл ажиллагаагаа явуулна.

Өмнийн Говийн бүсийн ханган нийлүүлэгчид нь одоогоор уул уурхайн салбарын тавигдах шаардлага болон хүлээлтийг сайн мэдэхгүйтэй холбоотой ихэнх тохиолдолд Оюу Толгойн шаардлагын дагуу өрсөлдөөнт тендэрүүдэд үр дүнтэй оролцож чадахгүй байгаа юм.

Өмнийн Говийн ханган нийлүүлэгчийн хөгжлийн бодлого нь Өмнийн Говийн ханган нийлүүлэгчдийг идэвхитэй оролцуулах, тухайн нөхцөл байдалд дасан зохицох арга замыг чиглүүлэх, уул уурхайн салбар болон үйлдвэрлэлийн стандартыг цаашид мөрдөн ажиллах чиглэлээр Оюу Толгойн хэрэгжүүлэх цаашдын арга замыг тодорхойлоход чиглэсэн.

Энэхүү асуудлыг гаргаж ирэхийн тулд Оюу Толгой нь дүн шинжилгээ хийх зорилгоор Өмнийн Говийн ханган нийлүүлэгчид тулгарч буй зарим нийтлэг үзүүлэлтүүд эсвэл бэрхшээлүүдийг гаргаж ирсэн. Ингэснээр эдгээр ханган нийлүүлэгчдийг үйл ажиллагаандаа байнга татан оролцуулахад зөв дэмжлэг үзүүлэх юм.

Өмнийн Говийн ханган нийлүүлэгчдийн өсөлт хөгжлийг чиглүүлэхийн тулд Оюу Толгой нь Өмнийн Говийн ханган нийлүүлэгчдэд олон янзаар туслан дэмжиж байна. Доор дурдсан хэд хэдэн хөгжлийн үйл явц нь Өмнийн Говийн ханган нийлүүлэгчдэд зориулагдсан юм. Эдгээр үйл явц нь ханган нийлүүлэгчийн хөгжлийн үндэсний бодлогын нэмэлт нэг хэсэг бөгөөд энэхүү бодлого нь Өмнийн Говийн ханган нийлүүлэгчид хамааралтай:

- **Даланзадгадын ханган нийлүүлэгчийн хөгжлийн төв:** Энэ нь Өмнийн Говийн аж ахуйн нэгжүүдэд сургалт, дадлага болон бизнесийн хөгжлийн дэмжлэгт хамрагдах боломжийг нээж өгөх бөгөөд яаралтай ханган нийлүүлэлтийн үед Оюу Толгой болон Монгол улсын зах зээлийн нийлүүлэлтийн стандарт шаардлагуудыг хангана.
- **Бичил зээлийн хөтөлбөр:** Энэхүү хөтөлбөр нь Өмнийн говьд байрладаг ханган нийлүүлэгчдэд жижиг зээлийг олгож жижгээс дунд хэмжээний үйлдвэрлэлийг бий болгох түүнчлэн одоогийн бизнесийн үйл ажиллагааны хүрээгээ өргөтгөх, хөрөнгө хуримтлалыг бий болгох боломжоор хангана.
- **Үнийн нэмэгдэл:** Үүний хүрээнд үнийн нэмэгдлийг зөвшилцөн (бараа үйлчилгээний ангилал болон ханган нийлүүлэгчийн хөгжлийн бодлогын стратегийг даган мөрдөж байгаагаас шалтгаалан үнийн нэмэгдэл нь 5-аас 25-н хувийн хооронд байна)
- **Ангилалын чиглэлүүд:** Өмнийн Говийн зарцуулалтын талаар ангилалын зорилтуудыг Оюу Толгой нь тодорхойлно. Бүх чиглэлүүдийн талаар жил бүр олон нийтэд зарлах бөгөөд



Оюу Толгойн худалдан авалтын цахим хуудсанд тавина. Өрсөлдөөнийг дэмжихийн тулд үндэсний ханган нийлүүлэгчдийн хувьд аливаа нэг худалдан авалтын чиглэл нь 80%-аас дээш байхгүй

- **Шинэчлэсэн төлбөрийн нөхцлүүд:** Оюу Толгой нь Өмнийн Говийн ханган нийлүүлэгчдэд шинэчлэсэн төлбөрийн нөхцлийг санал болгоно. (төлбөрийн хуваарь болон тогтоосон хугацаан дахь үзүүлж байгаа үйлчилгээний үр дүнтэй холбогдоно)
- **Давуу эрхтэй ханган нийлүүлэгч:** 2 буюу түүнээс дээш дэндэрт оролцогчид нь техникийн хувьд хангалттай, бүх бүрэлдэхүүн хэсгүүд нь ижил гэхдээ бага зэргийн үнийн зөрөөтэй тохиолдолд дотоодын болон олон улсын олон улсын ханган нийлүүлэгчдээс илүү Өмнийн Говийн ханган нийлүүлэгчдийг эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон байгаль орчны шаардлагуудыг хэрхэн хангалттай мөрдөж байгаад үндэслэн сонгоно.
- **Өөрчлөх эрх:** Доорхи нөхцөл байдлыг үндэслэн тэндэрийн үнэд засвар оруулах боломжийг Өмнийн Говийн ханган нийлүүлэгчдэд олгоно.
  - Хэрэв тэндэр нь 100,000 ам.доллараас дээш бол;
  - Хэрэв бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээ нь техникийн хувьд хангалттай бол

Хэрэв олон улсын болон дотоодын ханган нийлүүлэгчдийн хоорондын үнийн зөрүү нь 10% дотор байвал

*Орон нутгийн бизнес, эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр*

Орон нутгийн түвшинд *Орон нутгийн эдийн засаг, бизнесийг хөгжүүлэх хөтөлбөрөөр* дамжуулан Төслийн нөлөөллийн бүсэд бичил зээлийн санхүүжилтийг бий болгосон. Уг хөтөлбөрийн талаар товчлон танилцуулбал:

- Ерөнхий зорилго нь Өмнийн Говийн бүс нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг иргэд, бизнесийн байгууллагуудад зөвхөн уул уурхайн компаниуд төдийгүй орон нутаг, бүс нутаг, үндэсний бусад зах зээлд бараа, үйлчилгээ нийлүүлэхэд туслалцаа үзүүлэх;
- “Говийн хөгжил цэцэглэлт” нэртэй бичил зээлийн хөтөлбөрийн эхний үе шатыг 2011 оны 2 дугаар сард Ханбогд, Манлай сумдын Засаг даргын тамгын газар, ТББ, орон нутгийн арилжааны банкуудтай хамтран эхлүүлээд байна. 2011 оны 5 дугаар сарын байдлаар Оюу Толгой нь өөрийн түншүүдтэй хамтран **55 жижиг бизнесийн** байгууллагуудад хөрөнгө оруулалт хийж, тэдэнд зориулан эхний графикт сургалтыг зохион байгуулжээ. Мөн өөр **27 жижиг бизнесийн** байгууллага зөвхөн сургалтанд нь оролцжээ;
- Худалдаа, малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, уламжлалт хувцас хунар хийх, мод боловсруулах, ноос үйлдвэрлэх, нийтийн тээврийн үйлчилгээ, талх нарийн боовны үйлдвэрлэл, ресторан болон бусад бизнест бичил санхүүгийн зээл олгоод байна. Орон нутгийн аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг энэ хөтөлбөрт хамруулж байна.
- Газраа худалдсан болон нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан малчид, нөлөөлөлд эмзэг хүн ам (өрх толгойлсон эмэгтэйчүүд зэрэг) –ыг Хөтөлбөрт давуу эрхээр хамруулж, зээлийн эхний хүүгээс чөлөөлөх зэргээр нэмэлт туслалцаа үзүүлнэ.

Хөтөлбөрийг орон нутгийн хэд хэдэн байгууллагууд (тухайлбал Даланзадгад хотын Хөгжлийн шийдэл, Амжилтын томъёо зэрэг ТББ) хэрэгжүүлнэ. Монгол улсын Хаан, Хас банк уг хөтөлбөрт мөн оролцоно. Оюу Толгойгоос эдгээр банкуудын зээл олголтод зориулж “үр” санхүүжилтийг олгоод байна.

Оюу Толгой нь Даланзадгад сумын хүнсний ногоо нийлүүлэх хөдөө аж ахуйн хоршооллыг хөгжүүлэхэд хөрөнгө оруулсан. Цаашид үр тарианы үйлдвэрлэлийг эхний байдлаар голчлон Даланзадгад хотод хөгжүүлэхэд анхаарна. Учир нь энд ус болон бусад нөөц бэлэн бөгөөд тариалалт ч худалдааны хэмжээнд байна. 2011 оны сүүл гэхэд уурхайн кэмийн хэрэгцээний ингэний сүүг бүгдийг нь Ханбогд сум болон тус аймгийн бусад малчдаас худалдан авдаг болох зорилго тавиад байна.

## Нөлөөллийн зэрэглэл

Оюу Толгой төсөлтэй холбоотой бий болох шууд бус ажлын байр болон худалдан авалт нь төслийн нөлөөллийн бүс, цаашлаад Өмнөговьаймаг, Монгол улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтэд **зэрэг** нөлөө үзүүлэх учраас нөлөөлөл нь мөн **өргөн хүрээтэй** байна. Улс, бүс нутаг, орон нутгийн ханган нийлүүлэгчид, үйлчилгээ, бизнес эрхлэгчдийн хувьд таатай нөхцөл аль хэдийнэ бүрдээд байгаа учраас эергээр нөлөөлөх нь **гарцаагүй** байна. Төслийн барилгын болон үйлдвэрлэлийн үе шатуудад орон нутгийн ханган нийлүүлэгч, бизнесүүдийг дэмжих хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлснээр шууд бус хөдөлмөр эрхлэлт, ханган нийлүүлэлт, үйлчилгээний үр ашгийг **урт хугацаанд** хүртэх боломж бүрдэнэ. (өөрөөр хэлбэл , уурхайг урт хугацаанд ашиглахтай холбоотой).

## 9.4 ҮЛДЭГДЭЛ НӨЛӨӨЛЛИЙН ТОЙМ

Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой дараах гол нөлөөллүүд үүснэ:

- Барилгын ажлын шат болон уурхайн ашиглалтын нийт хугацаанд Оюу Толгой төсөл, төслийн гэрээт гүйцэтгэгчид ажлын байр бий болгосноор шууд хөдөлмөр эрхлэлт бий болно;
- Төсөлд шаардлагатай нөөц, бараа, үйлчилгээний эрэлт хэрэгцээнээс үүдэн шууд бус ажлын байр бий болсноор бизнесийн таатай орчинг бүрдүүлж, ханган нийлүүлэлт, үйлчилгээний салбарт ашигтай ажлын байр бий болох;
- Дээр тодорхойлсон нөлөөллүүдтэй шууд холбоотой сөрөг нөлөөллийг бууруулах, эерэг нөлөөллийг эрчимжүүлэхийн тулд давуу эрхээр ажилд авах, хөлслөх тухай Хөрөнгө оруулалтын гэрээнд заасны дагуу үндэсний болон орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтыг хангах;
- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг, ялангуяа тэднийг менежер, техникийн болон инженерийн албан тушаалд ажиллуулах явдлыг дэмжих;
- Монгол ажилчдад зориулж мэргэжлийн ба ур чадварын сургалтууд зохион байгуулж, мэргэжил дээшлүүлэх боломжоор хангах;
- Цомхотгох, ажиллах хүчийг халах асуудлыг урьдчилан төлөвлөх, (барилгын ажил дуусах, мөн уурхайн үйлдвэрлэлийн хугацаа дуусах үеийн аль алинд), энэ үйл явцыг Монгол улсын Хөдөлмөрийн хууль болон олон улсын заавар зөвлөмжийн дагуу гүйцэтгэн явуулах;
- Орон нутгийн бизнесийн чадавхийг бэхжүүлэх, өсөлтийг дэмжих өргөн хүрээний тусламж дэмжлэгийн хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлэх .

Дээр дурдсан нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр шууд болон шууд бус хөдөлмөр эрхлэлттэй холбогдон гарах үлдэх нөлөөллийг **зэрэг** гэж үнэлж байна.

Хүснэгт9.25-д нөлөөлөл болон бууруулах арга хэмжээний талаар товчлон харуулж, хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх үлдэх нөлөөллийн (бууруулах арга хэмжээ авсны дараа) зэрэглэлийг үнэлэв.

### Хүснэгт 9.2: Хөдөлмөр эрхлэлтийн нөлөөллийн хураангуй

| Нөлөөлөл  | (1)<br>Хүлээн<br>авагч                                      | (2)<br>Үе шат          | (3)<br>Нөлөөллийн<br>ангилал   | (4)<br>Нөлөөллийн<br>зэрэглэл | Төлөвлөх, сайжруулах, сөрөг нөлөөллийг<br>бууруулах аргахэмжээ  | Менежментийнтөлөвлөгөө,<br>бодлого, журам   | Үлдэх<br>нөлөөллийн<br>зэрэглэл |
|---|---|------------------------|--|-------------------------------|---|---|---------------------------------|
| Оюу Толгой төсөл болон түүний гэрээт гүйцэтгэгчдээс олргож буй шууд хөдөлмөр эрхлэлт, ур чадварыг хөгжүүлэх сургалт | Орон нутгийн, бүс нутгийн болон үндэсний нийт оршин суугчид | Барилгын Үйлдвэрлэлийн | <b>Үргэлжлэх хугацаа</b><br>Дунд хугацааны<br><br><b>Хамрах хүрээ</b><br>Өргөнхүрээний<br><br><b>Магадлал</b><br>Гарцаагүй | Зерэг                         | <ul style="list-style-type: none"> <li>■ Өмнийн Говийн хүн амын Хөдөлмөр эрхлэлт, ур чадварын тооллого болон мэдээллийн сан</li> <li>■ Монгол ажилчдыг авч ажиллуулах тогтоосон хувь хэмжээ. Барилга болон үйлдвэрлэл дээр ажиллах ажилчдад зориулсан ажлын байран дах болон мэргэжлийн сургалт.</li> <li>■ Орон нутгийн болон Монгол улсын оршин суугчдад давуу эрх олгож, ажлаар хангах.</li> <li>■ Барилгын болон үйлдвэрлэлийн шатанд ажлын байрны зарыг өргөнөөр хэвлэн нийтлүүлэх.</li> <li>■ Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг дэмжих.</li> <li>■ Орон нутгийн ажилчдад зориулан ажлын байранд бэлтгэгдэх болон бусад мэргэшүүлэх сургалт.</li> <li>■ Бичил санхүүжилт ба бусад схемээр уул уурхайн бус ажил эрхлэлт болон Бизнесийг хөгжүүлэх боломж олгох.</li> <li>■ Орон нутгийн болон Монгол ажиллах хүчинд зориулсан тусгай ажлын цаг ээлж.</li> <li>■ Зориулалтын ажилд бүртгэх төвүүд, ажилдаа үнэнч бүртгэлийн ажилтнууд</li> <li>■ Цалингийн харьцуулсан судалгаа явуулах .</li> <li>■ Шинээр техник мэргэжлийн 2 коллежийг байгуулах, одоогийн 5 техник мэргэжлийн коллежийг шинэчлэн засварлахад хувь нэмэр оруулах.</li> <li>■ ХН/ЭМАААБ болон бусад холбогдох стандартуудыг хангах Төслийн гэрээт гүйцэтгэгчид болон ханган нийлүүлэгчид .</li> <li>■ Оюу Толгой болон гэрээт гүйцэтгэгчдэд тогтмол аудит хийлгэх.</li> <li>■ Цомхотгох, халах асуудлыг урьдчилан төлөвлөх, удирдан зохицуулах.</li> <li>■ Рио Тинто компаний шугамаар ажилчдыг Олон</li> </ul> | Хөрөнгө оруулалтын гэрээ (ажилэрхлэлт басургалтын талаарх заалтууд)<br>ОТ-н ажилд авах бодлого журам<br>ОТ-н ялгаварлан гадуурхахын эсрэг бодлого<br>ОТ, ажилчдын гарын авлага<br>ОТ, кэмгийн бодлого, харилцааны ёсзүй<br>ОТ, 5 жилийн Сургалтын стратегиТөлөвлөгөө<br>ОТ, ажлын байрны талаар гомдол санал авах журам<br>Хөдөлмөрийн Менежментийн Төлөвлөгөө<br>Оролцогч ба сонирхогч талуудын оролцооны төлөвлөгөө | Зерэг                           |

| Нөлөөлөл  | (1)<br>Хүлээн<br>авагч                                      | (2)<br>Үе шат          | (3)<br>Нөлөөллийн<br>ангилал   | (4)<br>Нөлөөллийн<br>зэрэглэл | Төлөвлөх, сайжруулах, сөрөг нөлөөллийг<br>бууруулах аргахэмжээ  | Менежментийнтөлөвлөгөө,<br>бодлого, журам  | Үлдэх<br>нөлөөллийн<br>зэрэглэл |
|---|---|------------------------|--|-------------------------------|---|--|---------------------------------|
|   |   |                        |  |                               | <p>улсын солилцооны хөтөлбөрт хамруулах болон томилолтоор явуулах .</p> <ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн бизнес, аж ахуйн нэгж, нөлөөлөлд өртсөн малчдад зориулж янз бүрийн сургалтын санаачлагуудыг хэрэгжүүлэх</li> </ul>  |  |                                 |
| Бараа, үйлчилгээг ханган нийлүүлэхээс үүсэх шууд бус хөдөлмөр эрхлэлт | Орон нутгийн, бүс нутгийн болон үндэсний нийт оршин суугчид | Барилгын Үйлдвэрлэлийн | <p><b>Үргэлжлэх хугацаа</b><br/>Урт хугацааны</p> <p><b>Хамрах хүрээ</b><br/>Өргөнх үрээний</p> <p><b>Магадлал</b><br/>Гарцаагүй</p> | Эерэг                         | <ul style="list-style-type: none"> <li>Монгол улсын ханган нийлүүлэгчид, үйлчилгээ үзүүлэгчдийг бүс нутаг, орон нутгаар нь тодорхойлж, мэдээллийн сан байгуулах .</li> <li>Төслийн хангамжийн үйл ажиллагаанд үндэсний, бүс нутаг, орон нутгаас хийх худалдан авалтыг нэн тэргүүнд тавих.</li> <li>Орон нутгийн бизнесийг хөгжүүлэхэд тусламж дэмжлэг үзүүлэх</li> <li>Жижиг дунд бизнест олгох бичил зээлийг санхүүжүүлэхэд банкуудтай хамтран ажиллах.</li> <li>Ханган нийлүүлэгчдийг хөгжлийн төв байгуулах.</li> <li>Төслийн нөлөөллийн бүс дэх бизнес эрхлэгчдийг сургалт, техникийн тусламж үзүүлэх хөтөлбөр, зах зээлд өрсөлдөх үйл ажиллагаагаар хангах.</li> <li>Орон нутгийн Эдийн засаг, бизнесийг хөгжүүлэх хөтөлбөрийн нэг хэсэг болгож малчид болон эмзэг хүн амыг нэн тэргүүнд хамруулах, нэмэлт дэмжлэг үзүүлэх .</li> <li>Орон нутгийн хөдөө аж ахуйн бизнесийг зорилтот худалдан авалтаар дамжуулан хөгжүүлэх.</li> </ul> | Худалдан авалт болон Орон нутгийн ханган нийлүүлэгчдийг дэмжих төлөвлөгөө<br>Орон нутгийн бизнес, эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр<br>Оюу Толгойн ханган нийлүүлэгчдийг хөгжлийн бодлого<br>Хөдөлмөрийн менежментийнтөлөвлөгөө | Эерэг                           |

| Нөлөөлөл                                 | (1)<br>Хүлээн<br>авагч                                 | (2)<br>Үе шат   | (3)<br>Нөлөөллийн<br>ангилал   | (4)<br>Нөлөөллийн<br>зэрэглэл | Төлөвлөх, сайжруулах, сөрөг нөлөөллийг<br>бууруулах аргахэмжээ   | Менежментийнтөлөвлөгөө,<br>бодлого, журам  | Үлдэх<br>нөлөөллийн<br>зэрэглэл |
|--|--|---|--|-------------------------------|--|--|---------------------------------|
| Шууд ба шууд бус хөдөлмөр эрхлэлт буурах | Орон нутгийн, бүс нутгийн болон үндэсний оршин суугчид | Үйлдвэрлэлийн үе шат руу шилжих үе, ба Хаалтын үе руу ойртох үе | <b>Үргэлжлэх хугацаа</b><br>Дунд хугацааны<br><br><b>Хамрах хүрээ</b><br>Өргөнхүрээний<br><br><b>Магадлал</b><br>Гарцаагүй | Их хэмжээний сөрөг            | <ul style="list-style-type: none"> <li>■ Орон нутгийн бизнесийг хөгжүүлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлэх</li> <li>■ Жижиг дунд бизнест олгох бичил зээлийг санхүүжүүлэхэд банкуудтай хамтран ажиллах.</li> <li>■ Ханган нийлүүлэгчдийг хөгжлийн төвүүдийг байгуулах.</li> <li>■ Төслийн нөлөөллийн бүс дэх бизнес эрхлэгчдийг сургалт, техникийн тусламж үзүүлэх хөтөлбөр, зах зээлд өрсөлдөх үйл ажиллагаагаар хангах.</li> <li>■ Орон нутгийн Эдийн засаг, бизнесийг хөгжүүлэх хөтөлбөрийн нэг хэсэг болгож малчид болон эмзэг бүлгийн хүн амыг нэн тэргүүнд хамруулах, нэмэлт дэмжлэг үзүүлэх</li> <li>■ Орон нутгийн хөдөө аж ахуйн бизнесийг зорилтот худалдан авалтаар дамжуулан хөгжүүлэх.</li> <li>■ Бусад уул уурхайн компаниудын ажиллах хүчийг дэмжихэд сургалт явуулах.</li> <li>■ Бусад дотоодын үйл ажиллагаанд тархаан байршуулах (Рио Тинто/Айвенхоу Майнз)</li> </ul> | Ороннутгийнтогтвортой бизнесийн орчныг дараах зүйлсээр дамжуулан хөгжүүлэх :<br>Орон нутгийн Бизнес, эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр<br>Оюу Толгойн Худалдан авалтын зарчмууд болон бодлогууд Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөө | Дунд зэргийн сөрөг              |

Тайлбар:

**(1) Эн тэргүүний хүлээн авагч:** нөлөөлөлд өртсөн эсвэл бусад сонирхогч талууд

**(2) Төслийн үе шат:** Барилгын ажлын, Үйлдвэрлэлийн, Уурхайн татан буулгалт ба Уурхайн хаалтын

**(3) Нөлөөллийн ангилал:**

Үргэлжлэх хугацаа: Богино хугацааны, Дунд хугацааны, Урт хугацааны

Хамрах хүрээ: зөвхөн орон нутгийн шинжтэй; орон нутгийн шинжтэй; хязгаарлагдмал; өргөн хүрээний

Магадлал: магадлал маш бага; магадлал багатай; магадлалтай; гарцаагүй

**(4) Нөлөөллийн зэрэг:** Их сөрөг; дунд зэргийн сөрөг; бага зэргийн сөрөг; нөлөөгүй; Эерэг

---

## Орчуулгын үнэн зөвд баталгаа гаргахаас татгалзах тухай

Оюутолгой төслийн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг англи хэл дээр боловсруулж, монгол хэл рүү орчуулав.

Оюутолгой ХХК уг үнэлгээг монгол хэл рүү нягт нямбай, үнэн зөв орчуулахад хичээнгүйлэн ажилласан болно. Гэвч орчуулгын элдэв хүндрэлээс шалтгаалж, англи болон монгол хувилбарын хооронд ямар нэг зөрүү гарч болохыг үгүйсгэх аргагүй юм. Хэрэв орчуулгын үнэн зөвтэй холбоотой ямар нэгэн эргэлзээ төрвөл баримт бичгийн албан ёсны хувилбар болох англи хувилбарыг уншина уу.

Оюутолгой ХХК нь орчуулгын үнэн зөв, бүрэн төгс байдлын талаар ямар нэг баталгаа гаргахгүй бөгөөд Оюутолгой ХХК нь орчуулгатай холбогдон шууд болон шууд бусаар үүссэн аливаа (Гэрээ, хэлцэл, гэм хорын дагуу буюу холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үүссэн г.м) хохирлыг хариуцахгүй болно.

Та уг орчуулгын алдаа, дутагдал болон орчуулгыг сайжруулах талаарх санал, зөвлөмжөө [OTESIA@ot.mn](mailto:OTESIA@ot.mn) хаягаар ирүүлнэ үү.